



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 09 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Заавар, загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Гамшигаас хамгаалах улсын албаны газар хөдлөлтийн бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулах нийтлэг заавар”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Гамшигаас хамгаалах улсын албаны газар хөдлөлтийн бэлэн байдлын төлөвлөгөөний загвар”-ыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
- Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гамшигаас хамгаалах улсын албаны дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД

С.АМАРСАЙХАН



0023100189



Монгол Улсын Шадар сайдын 2023 оны
25 дугаар сарын 09ны өдрийн 31 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Газар хөдлөлтийн гамшгийн үед гамшгаас хамгаалах улсын алба, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний үйл ажиллагааг төлөвлөх хүч хэрэгслийг хуваарилах, гамшгийн хор уршигийг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг шуурхай, үр дүнтэй төлөвлөж хэрэгжүүлэхэд энэхүү зааврын зорилго оршино.

1.2. Гамшгаас хамгаалах улсын албаны газар хөдлөлтийн бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулахдаа Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Нөөцийн тухай хууль, MNS 6980:2022 “Гамшгийн аюулыг зарлан мэдээлэх үйл ажиллагаа” стандарт, Монгол Улсын Шадар сайдын 2018 оны 120 дугаар тушаал болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3. Гамшгаас хамгаалах улсын албад энэхүү зааврыг үндэслэн газар хөдлөлтийн бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулна.

Хоёр. Төлөвлөгөөний ерөнхий бүтэц

2.1. Төлөвлөгөө нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Хоёрдугаар бүлэг. Улсын албаны газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ;

- Барилга, байгууламж, дэд бүтцийн мэдээлэл;
- Тооцоо, судалгаа (хүн, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, байр, эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнс, шатахуун г.м);
- Гамшгийн нөөцийн мэдээлэл судалгаа

Гуравдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн үеийн хариу арга хэмжээ

- Аврах, хор уршигийг арилгах төлөвлөгөө
- Мэргэжлийн ангийн томилгоот бүрэлдэхүүн
- Дайчлах хүч хэрэгсэл

Дөрөвдүгээр бүлэг. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ;

- Эрсдэлийн үнэлгээнд үндэслэсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө
- Удирдлага, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүний сургалт, дадлага

Тавдугаар бүлэг. Газар хөдлөлтийн гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөлт;

- Нөөц бүрдүүлэлт;

Гурав. Төлөвлөгөө боловсруулах дараалал

3.1. Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн үүсч

болзошгүй хохиролын үнэлгээ, хүч хэрэгсэл, нөөцийг тооцох;

3.2. Салбарын бүтэц зохион байгуулалт, үндсэн чиг үүрэг, харьяа байгууллага, албан хаагчид, төсөв, зардал, барилга байгууламж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бодитой тооцоолох;

3.3. Түр цугларах талбай, нүүлгэн шилжүүлэх болон түр байрны байршил, багтаамж, зам, хөдөлгөөний чиглэлийг тодорхойлох;

3.4. Тухайн салбарын гүйцэтгэх үүрэг чиглэлтэй уялдуулан учирч болзошгүй хүндрэл, бэрхшээл, шийдвэрлэх арга замыг тодорхойлох;

3.5. Хүнс, шатахуун, бусад бараа материалын хангалтыг хэрхэн зохион байгуулах;

3.6. Албаны удирдлага зохион байгуулалт, штаб, мэргэжлийн ангийн бүтэц, зохион байгуулалт тэдгээрийн гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;

Дөрөв. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх,
эрсдэлийг бууруулах арга хэмжээ

4.1. Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ болон үүсч болзошгүй цагийн байдлын төсөөлөлд үндэслэнэ.

4.2. Газар зүйн мэдээллийн системд сууринсан гамшгийн эрсдэлийн зураглал, мэдээллийн сан бий болгох, хөгжүүлэх;

4.3. Салбарын хэмжээнд үйл ажиллагааныхаа онцлогт нийцүүлэн зарлан мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлж бүх төрлийн харилцаа холбооны суваг болон зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангах;

4.4. Гамшгийн үед ашиглах бүх төрлийн нөөцийг бүрдүүлэх;

Тухайлбал: Улсын алба, мэргэжлийн ангийг өргөтгөн ажиллуулах, нөхөн хангаль хийх зорилгоор бүх шатны Засаг даргын Тамгын газар, Цэргийн штаб, Эрүүл мэндийн байгууллагатай хамtran барилга байгууламж, техник, материал хэрэгслийг татан оролцуулах талаар тусгана.

4.5. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний бат бэх найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах, хүчитгэх, шинэчлэн барих;

4.6. Гамшигт нэрвэгдэгсдэд нэн шаардлагатай хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, эрчим хүч, дулаанаар тасралтгүй хангах асуудлыг тусгах;

Тухайлбал: Гамшгаас хамгаалах улсын алба газар хөдлөлтийн гамшиг тохиолдсон үед эрэн хайх, аврах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээг хэрэгжүүлэх, хэрэгцээт хоол хүнсний тооцоо, судалгаа гаргаж нөөцлөх

4.7. Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургууль, удирдах бүрэлдэхүүн, алба, мэргэжлийн ангийн сургалтыг зохион байгуулах.

4.8. Гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгах,

Тав. Газар хөдлөлтийн гамшгийн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1. Салбарын хэмжээнд зарлан мэдээлэл дамжуулах, харилцаа холбоо зохион байгуулах;

5.2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх,

холбогдох шийдвэрийг гаргах;

5.3. Улсын албаны чиг үүргийн хүрээнд голомтын бүсийг тогтоох, нөхцөл байдлын анхдагч үнэлгээг хийх, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах;

5.4. Гамшгаас хамгаалах улсын албаны шуурхай штаб байгуулж, үүссэн нөхцөл байдлыг үнэлэх, аврах, тусгай чиг үүргийн шуурхай бүлэг томилон ажиллуулах;

5.5. Гамшгийн голомтод зам гарцыг чөлөөлж, хязгаарлалтын бүс тогтоож эрэн хайх, аврах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоог хангах;

5.6. Улсын онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн байгууллагуудтай харилцан ажиллагааг зохицуулах, мэдээ, мэдээлэл солилцох арга хэмжээг шуурхай авах;

5.7. Онц чухал объектыг хамгаалалтад авах, зам талбай, харилцаа холбоо, цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны инженерийн барилга, байгууламж, дэд бүтцийн эвдрэл гэмтлийг тодорхойлох, хоёрдогч хөнөөл үүсэхээс хамгаалах арга хэмжээг тодорхой тусгах;

5.8. Голомтод үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүн, нэрвэгдэгсдэд бүх төрлийн хангалтыг зохион байгуулах (хоол хүнс, байр сууц, эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж үйлчилгээ, дулаан хувцас, шатах тослох материал г.м.);

5.9. Түр цугларах талбайд ажилтан, албан хаагчдыг бүртгэх, зааварчилгаа өгөх, нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах;

5.10. Салбарын чиг үүргийн хүрээнд хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэсэн бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар тусгах;

Тухайлбал: Нэрвэгдэгсдийг эрэн хайх, аврах, эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, эрэмбэлэн ангилах, аюулгүй газар шилжүүлэх, тээвэрлэх, түр байр, эмнэлэг дэлгэх, цогцос зөөвөрлөх, хадгалах, таниулах, оршуулах, дэд бүтцийг сэргээх (эрчим хүч, дулаан, зам, харилцаа холбоо г.м) зам гарц чөлөөлөх, ажлыг зохион байгуулах.

5.11. Нэрвэгдэгсэдийг хүлээн авах, дамжин өнгөрүүлэх, хүмүүнлэгийн тусламж үйлчилгээг хүргэх, зохион байгуулахад алба, мэргэжлийн анги, холбогдох байгууллагуудыг татан оролцуулахаар төлөвлөх;

5.12. Түр байранд иргэдийг хүлээн авах, шаардлагатай хоол, хүнс, дулаан хувцасны хангалт, эмнэлгийн анхны тусламж, сэтгэл зүйн болон бусад төрлийн тусламж үзүүлэх;

5.13. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтооолоор баталсан “Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршигийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө”-ний дагуу харилцан ажиллагааг зохион байгуулах;

Зургаа. Газар хөдлөлтийн гамшгийн дараах хойшлуулшгүй
сэргээн босгох арга хэмжээ

6.1. Салбарын хэмжээнд хохирлын үнэлгээ, дүн шинжилгээнд үндэслэн хийгдэх ажлыг эрэмбэлэх, зохион байгуулах;

Тухайлбал: Гамшгийн голомтод барилга, дэд бүтцийн байгууламжийг үе шаттайгаар сэргээн засварлах, нуранги, хог хаягдлыг зайлцуулах, зам гарцыг

чөлөөлөх, орчны бохирдлыг саармагжуулах, хоёрдогч хөнөөл үүсэхээс урьдчилан сэргийлэх зэрэг ажилд чиг үүргийн дагуу оролцно.

6.2. Газар хөдлөлтийн гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах зардал, хөрөнгийг тооцож тусгана.

Долоо. Хавсралт

7.1. Төлөвлөгөөний хавсралтад дараах бичиг баримтыг боловсруулж бүрдүүлнэ:
Үүнд:

- Засгийн газар, Улсын онцгой комиссын тогтоолын төсөл,
- Улсын албаны даргын тушаал шийдвэрийн баримт бичгийн төсөл (цахим болон цаасан хэлбэрээр),

7.2. Улсын албаны онцлогоос шалтгаалан газар хөдлөлтийн үед ажиллах үндсэн болон нөөц хүч хэрэгслийн судалгаа, тооцоо;

7.3. Нэн чухал дэд бүтэц (цахилгаан, дулаан, цэвэр бохир усны шугам, харилцаа холбоо, зам гүүр г.м), барилга, байгууламжийг сэргээн засварлахад шаардагдах тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, бараа материалын нөөцийн судалгаа;

7.4. Гамшигт өртсөн, түр байранд байрлуулсан иргэд, голомтод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын хүнс, орон байр, дулаан хувцас, шатахуун болон бусад хэрэгцээт бараа материалыар хангах тооцоо судалгаа;

7.5. Эрэн хайх, аврах ажиллагаа явуулах, нэрвэгдэгсдийг нүүлгэн шилжүүлэх зам гарцыг тэмдэглэсэн байр зүйн болон план зураг.

Найм. Төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал


8.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах, сэргээн босгох үйл ажиллагааг уялдуулан зохицуулахад мэргэжлийн байгууллагын үүрэг, оролцоо, үүсч болзошгүй нөхцөл байдалд тулгуурласан бодитой байх, үндсэн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой тусгасан байх;

8.2. Олон улсын туршлагыг судалж, шаардагдах мэдээ, мэдээллийг боловсруулж, холбогдох байгууллагын мэргэжлийн хүмүүсийн оролцоог хангасан байх.

8.3. Улсын онцгой комиссын дэргэдэх Онцгой байдлын ажиллагааны удирдлагын төвд ажиллах албан хаагчийг томилгоожуулах, тогтвортой ажиллах, сургалтад хамруулах.

8.4. Гамшгаас хамгаалах улсын албаны төлөвлөгөөний дагуу ажиллах чадвартай байх

---оОо---



Монгол Улсын Шадар сайдын 2023 оны
05 дугаар сарын 29-ны өдрийн 31 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

БАТЛАВ:
ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ ДАРГА

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ
ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАГВАР

ХЯНАСАН: ОБЕГ-ЫН АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

БОЛОВСРУУЛСАН: ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ
ГАМШГААС ХАМГААЛАХ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ

д/д	Гарчиг	Хуудасны дугаар
1	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл 1.1. Зорилго 1.2. Төлөвлөгөө боловсруулахад баримталсан зарчим 1.3. Хамрах хүрээ	
2	Хоёрдугаар бүлэг. Гамшгаас хамгаалах улсын албаны танилцуулга	
3	Гурав. Эрсдэлийн үнэлгээ	
4	Дөрөв. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, газар хөдлөлтийн үеийн хариу арга хэмжээ, газар хөдлөлтийн гамшгийн дараах хойшлуулшгүй сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө	
5	Хавсралт /захирамжлалын баримт бичгийн төсөл, зарлан мэдээллийн схем, хүч хэрэгслийн тооцоо судалгаа, нөөц, хангамжийн судалгаа, байр зүйн болон план зураг гэх мэт/	

**ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ
ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Зорилго:

.....

1.1. Хамрах хүрээ

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ ТАНИЛЦУУЛГА

2.1. Товч танилцуулга

Албаны байршил хаяг:

Байгуулагдсан огноо:

Хамрах нутаг дэвсгэр:

Хариуцах чиг үүрэг:

Хүч хэрэгсэл: гамшгаас хамгаалах улсын алба нь нийт ... хүн, хүч хэрэгсэл ... үүнээс техник, багаж хэрэгсэл....., барилга байгууламжбайна.

№	Улсын албаны нэр	Нэгжийн тоо	Хүний тоо	Машин техник	Барилга байгууламж объект м2
1	Бүрэлдэхүүн	1	10	2	
2	Тусгай зориулалтын техник				
3	Багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж				
4	Хөдөлгөөнт лаборатори				
5	Харьяа нэгж				
6	Төрийн бус байгууллага \ холбоо\				
7	Сайн дурын хэсэг ...гэх мэт				
	Нийт				

/дэлгэрэнгүй судалгааг хавсралт-р хуудсанд үзүүлэв/

-нөөц хэрэгсэлийг төрөл тус бүрээр гаргаж бичнэ.

Статистик үзүүлэлт:

ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

.....

ДӨРӨВ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ҮЕИЙН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ, ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ДАРААХ ХОЙШЛУУЛШГҮЙ СЭРГЭЭН БОСГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хариуцах байгууллага	Үйл ажиллагаа	Хугацаа	Дэмжлэг үзүүлэх байгууллага	Тайлбар
А. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ТАЛААР					
1		Албаны хэмжээнд газар хөдлөлтийн ерөнхий болон нарийвчилсан эрсдэлийн үнэлгээ хийх (барилга байгууламж, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний найдвартай ажиллагааны түвшинд мэргэжлийн дүгнэлт гаргах)			
		Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалт зохион байгуулах			
		Газар хөдлөлтийн гамшгийн үед удирдлага, зохион байгуулалтаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус удирдлагын бүрэлдэхүүнийг томилох			
		Бие бүрэлдэхүүн, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлэн байдлыг хангах, сургалтын материал, гарын авлагатай болох			
		Салбарын хэмжээнд үйл ажиллагааныхаа онцлогт нийцүүлэн зарлан мэдээлэл дамжуулах нөхцөлийг бүрдүүлж бүх төрлийн харилцаа холбооны суваг болон зарлан мэдээллийн системийн байнгын бэлэн байдлыг хангасан байх			
		Зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургууль зохион байгуулах			
		Ажилтануудын аюулгүй байдлыг хангах, түр цугларах талбай (80 хувь гарах багтаамжтай, тэмдэг тэмдэглэгээтэй, нутгийн захиргааны байгууллагаар баталгаажуулсан)-тай байх			
		Газар хөдлөлтийн үед хэрэглэх бүх төрлийн нөөцийг бүрдүүлсэн байх (гамшигт нэрвэгдэгсдэд нэн шаардлагатай хоол хүнс, ус, хувцас хэрэгсэл, эм, эмнэлгийн бүтээгдэхүүн, ороох боох материал, түр орогнох байр г.м)			
		Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шаардагдах зардлыг төсөвт тусгах,			

Б. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ҮЕД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

1		Албаны хэмжээнд зарлан мэдээллийн дохио дамжуулах;			
		Түр цугларах талбайд ажилтан, албан хаагчийг бүртгэх, зааварчилгаа өгөх, нүүлгэн шилжүүлэх ажиллагааг зохион байгуулах;			
		Улсын онцгой комисс, гамшгаас хамгаалах улсын албад, мэргэжлийн байгууллагуудтай мэдээ, мэдээлэл солилцох, харилцан ажиллагааг зохицуулах арга хэмжээг шуурхай авах;			
		Албаны хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, шуурхай штаб, томилгоот бүлгийг байгуулах, холбогдох шийдвэрийг гаргах;			
		баригла, байгууламж, дэд бүтцийн эвдрэл гэмтлийг тодорхойлох, нөхцөл байдлын анхдагч үнэлгээг хийж, голомтын бүсийг тогтоох, хоёрдогч хөнөөл үүсэхээс сэргийлэх, арга хэмжээний санал боловсруулах;			
		Гамшгийн голомтод зам гарцыг чөлөөлж, албаны онц чухал объектыг хамгаалалтад авах, хязгаарлалтын бүс тогтоох;			
		Эрэн хайх, аврах, эмнэлгийн яаралтай тусlamж үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, нүүлгэн шилжүүлэх, түр байранд байрлуулах			
		Голомтод үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүн, нэрвэгдэгсдэд бүх төрлийн хангалтыг зохион байгуулах (хоол хүнс, байр сууц, эм, эмнэлгийн хэрэгсэл, дулаан хувцас, шатах тослох материал г.м.);			
		Хохирол, хэрэгцээний анхдагч үнэлгээ хийх, шаардлагатай хүч хэрэгслийг татан оролцуулах, хүн, техник, бараа материалыг хуваарилах;			
		Нэрвэгдэгсдэд хүмүүнлэгийн тусlamж үйлчилгээг хүргэх, зохион байгуулахад алба, мэргэжлийн анги, холбогдох байгууллагуудыг татан оролцуулахаар төлөвлөх;			
Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 416 дугаар тогтоолоор баталсан "Гамшгийн аюулаас хүн ам, эд хөрөнгө, мал амьтныг урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй					

		сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө"-ний дагуу харилцан ажиллагааг зохион байгуулах;		
		Салбарын чиг үүргийн хурээнд хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэсэн бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар тусгах;		
		Түр байранд иргэдийг хүлээн авах, шаардлагатай хоол, хүнс, дулаан хувцасны хангарт, эмнэлгийн анхны тусlamж, сэтгэл зүйн болон бусад төрлийн тусlamж үзүүлэх;		
		Эрхэлсэн салбарын тогтвортой үйл ажиллагааг ханга		
		В. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ДАРАА АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ		
1		Салбарын хэмжээнд хохирол, хэрэгцээний үнэлгээ гаргах		
		Газар хөдлөлтийн гамшгийн дараах хоёрдогч гамшиг (халдварт өвчин г.м) үүсэхээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг төлөвлөж, шуурхай авч хэрэгжүүлэх		
		Хохирол хэрэгцээний үнэлгээнд үндэслэн авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлэх, төлөвлөх		
		Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах техник, тоног төхөөрөмж, зардал, хөрөнгийг тооцох		
		Гамшигт өртсөн дэд бүтэц, барилга байгууламжийг үе шаттайгаар сэргээн засварлах, нуранги, хог хаягдлыг тээвэрлэх, устгах, зам гарцыг чөлөөлөх, орчны бохирдлыг саармагжуулах, хоёрдогч хөнөөл үүсэхээс урьдчилан сэргийлэх		
		Олон улсын болон дотоодын хандив, хүмүүнлэгийн тусlamжийг хүлээн авах, хуваарилах, тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулах		

		сэргээн босгох арга хэмжээний төлөвлөгөө"-ний дагуу харилцан ажиллагааг зохион байгуулах; Салбарын чиг үүргийн хүрээнд хохирол, хэрэгцээний үнэлгээнд үндэслэсэн бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар тусгах; Түр байранд иргэдийг хүлээн авах, шаардлагатай хоол, хүнс, дулаан хувцасны хангалт, эмнэлгийн анхны тусlamж, сэтгэл зүйн болон бусад төрлийн тусlamж үзүүлэх; Эрхэлсэн салбарын тогтвортой үйл ажиллагааг ханга			
В. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ДАРАА АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ					
		Салбарын хэмжээнд хохирол, хэрэгцээний үнэлгээ гаргах			
		Газар хөдлөлтийн гамшгийн дараах хоёрдогч гамшиг (халдварт өвчин г.м) үүсэхээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг төлөвлөж, шуурхай авч хэрэгжүүлэх			
		Хохирол хэрэгцээний үнэлгээнд үндэслэн авч хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлэх, төлөвлөх			
1		Хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд шаардагдах техник, тоног төхөөрөмж, зардал, хөрөнгийг тооцох			
		Гамшигт өртсөн дэд бүтэц, барилга байгууламжийг үе шаттайгаар сэргээн засварлах, нуранги, хог хаягдлыг тээвэрлэх, устгах, зам гарцыг чөлөөлөх, орчны бохирдлыг саармагжуулах, хоёрдогч хөнөөл үүсэхээс урьдчилан сэргийлэх			
		Олон улсын болон дотоодын хандив, хүмүүнлэгийн тусlamжийг хүлээн авах, хуваарилах, тээвэрлэн хүргэх ажлыг зохион байгуулах			

Хүснэгт 2

ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГИЙН ҮЕИЙН ЗАРЛАН МЭДЭЭЛЭЛ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээнүүд	Хугацаа																
		Минут						Цаг										
		10	20	30	40	50	60	2	4	6	8	10	12	14	16	18	20	22
1.	Зарлан мэдээллийн дохиог хүлээн авах, дамжуулах																	
2.	шуурхай штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг цуглуулах																	
3.	Хүн хүч, техник хэрэгслийг бэлэн байдалд оруулах																	
4.	Удирдлагын байрыг бэлэн байдалд оруулах																	
5.	Гамшигаас хамгаалах төлөвлөгөөг тодотгох урьдчилсан тооцоо гаргах																	
6.	Гамшигийн голомтоос мэдээ авах, нөхцөл байдлыг үнэлж даргын шийдвэр гаргах																	
7.	Мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах																	
8.																	
9.																	
10.																	


Тайлбар :



Үйл ажиллагаа эхэлсэн байх хугацааны дээд хязгаар (Ч+ цаг)

Зураглал 1.

ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИО ДАМЖУУЛАХ, ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮДҮҮВЧ



ХАВСРАЛТ

/ЗАХИРАМЖЛАЛЫН БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ ТООЦОО, СУДАЛГАА/

Жишээ загварууд

ЗАХИРАМЖ

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх,
улсын албаны штаб, мэргэжлийн анги байгуулах тухай

20.... оны сарынны өдөр

Гамшгаас хамгаалах тухай хуулийн заалт, Засгийн газрын тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Гамшгаас хамгаалах улсын албыг өдрөөс өдрийг хүртэл гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.
2. Гамшгаас хамгаалах улсын албаны шуурхай штабын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Штаб, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж дадлагажуулах, шаардлагатай хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх багаж хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулахыг штабын дарга /...../-д үүрэг болгосугай.
4. Штаб, мэргэжлийн ангийг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, үүрэг гүйцэтгэх багаж хэрэгслээр хангахад шаардагдах төгрөгийг зардлаас гаргаж зарцуулахыг Хангарт хариуцсан туслах /...../-д зөвшөөрсүгэй.

ДАРГА /

Гамшгаас хамгаалах улсын албаны даргын
20... онысарын-ны өдрийн
.....тушаалын 1 дүгээр хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН АЛБАНЫ ШТАБЫН БҮРЭЛДЭХҮҮН

д/д	Албан тушаал			Овог нэр
	Үндсэн албан тушаал	Томилгоожсон /Штабын/	Орлох албан тушаалтан	
1	Төрийн захиргааны байгууллагад тухайн байгууллагын даргын томилсон албан тушаалтан	Штабын дарга		
2	Тухайн байгууллагын нэгжийн дарга	Штабын орлогч		
3	Тухайн байгууллагын гамшгаас хамгаалах асуудал хариуцсан орон тооны ажилтан	Гамшгаас хамгаалах асуудал хариуцсан албан хаагч		
4	Тухайн байгууллагын мэдээлэл, холбооны асуудал хариуцсан нэгжийн ажилтан	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан ажилтан		
5	Тухайн байгууллагын сургалтын асуудал хариуцсан нэгжийн дарга	сургалт, мэргэжлийн ангийн бэлтгэл, бэлэн байдал хариуцсан ажилтан		
6	Тухайн байгууллагын санхүү, хангалтын асуудал хариуцсан нэгжийн дарга	Санхүү, хангалт хариуцсан ажилтан		
	Тухайн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан албан тушаалтан	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан		
		Бусад- гэх мэт		

Эрхэлсэн салбарын болон гамшгийн нөхцөл байдал /хамрах хүрээ, цаг хугацаа, болзошгүй хохирол, үр дагавар-/ын онцлогоос шалтгаалан холбогдох албан тушаалтан, ажлын хэсгийг тухай бүр томилон ажиллуулж болно.

Гамшгаас хамгаалах улсын албаны даргын
20... онысарын-ны өдрийн
.....тушаалын 2 дугаар хавсралт

МЭРГЭЖЛИЙН АНГИЙН ТОМИЛГООТ БҮРЭЛДЭХҮҮН

Д/д	Албан тушаал		Овог нэр	танилцсан албан тушаалтны гарын үсэг
	Үндсэн	Томилгоожсон		

Нэг: Тусгай зориулалтын мэргэжлийн бүлэг

1				
2				

Хоёр. Сайн дурын бүлэг

1				
2				

Гурав. Бусад

1				
2				

2. ГАМШГААС ХАМГААЛАХ.....УЛСЫН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ЧАДАВХЫН СУДАЛГАА

д/д	Байгууллагын нэр	Харяа байгууллага	Хүний нөөц, мэргэжлийн ур чадварын судалгаа				
			Хүн хүчний тоо				Бусад
1	-						
2							
3						
4						

ГАМШГААС ХАМГААЛАХ.....УЛСЫН АЛБАНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН АШИГЛАЛТЫН БАЙДАЛ

Байгууллага	Барилгын				Оршин суугчид		Барилгын төлөв байдал
	төрөл	Хийцийн ангилал	Давхарын тоо	Ашиглалтанд орсон огноо	Ажлын цагаар	Ажлын бус цагаар	
Төв байр	Офиссын барилга						
	Агуулахын барилга						

ГАМШГААС ХАМГААЛАХ.....УЛСЫН АЛБАНЫ АВТОМАШИН, ТЕХНИК ХЭРЭГСЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ

д/д	Гамшгаас хамгаалах алба	Автомашин техник				Хүнд механизмын		Чиргүүл			Хариуцах албан тушаалтан
		Сүүдлын	Ачааны	Автобус	Тусгай зориулалттын	Бүгд	Тусгай	Бага оврын	Трактор	1 голт	

ГАМШГААС ХАМГААЛАХ.....УЛСЫН АЛБАНД АШИГЛАГДАЖ БАЙГАА ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН БАГАЖ ХЭРЭГСЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ

/багаж хэрэгслийн судалгааг төрөл тус бүрээр гаргаж болно/

д/д	Газар	Техник, багаж хэрэгслийн нэр	Дансаар одоо байгаа	Дутагдаж байгаа	Бүгд	Чанар байдал	Хариуцах албан тушаалтан
						